



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар АЧБЖ

Улаанбаатар хот

Г Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дахь заалт, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Фортис эмнэлгээс Хавдар судлалын үндэсний төвтэй 2019 оны 3 дугаар сарын 13, Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД




Д.САРАНГЭРЭЛ

2019-A-tushaal

081941

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 10 сарын 14-ны өдрийн  
МҮБХ дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Вивек Виж Vivek Vij	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Хавдар судлалын үндэсний төв  Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Фортис эмнэлэг	ГЭ0002475	Мэс засал судлал	Эмчлэх	2019.10.21-2019.10.24 /4 хоног/